



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ДАРГА ГОМБОЖАВЫН ЗАНДАНШТАР  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Нямаагийн ЭНХБОЛД

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
Утас: 26-03-85, Факс: 26-29-92  
E-mail: enkhbold@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2022.01.19 № ЧИК-03/578

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г

Г

Хуулийн төсөл өргөн  
мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлын нэр бүхий гишүүд бид "Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийг санаачлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, Засгийн газраас ирүүлсэн дүгнэлтийг хавсаргав.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Н.ЭНХБОЛД

Б.БАТ-ЭРДЭНЭ

Б.ДҮРЭВДОРЖ

Ц.СЭРГЭЛЭН

Г.ТЭМҮҮЛЭН

Б.ЭНХ-АМГАЛАН

000008



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Нямаагийн ЭНХБОЛД

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
Утас: 26-03-85, Факс: 26-29-92  
E-mail: enkhbold@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2022.01.17 № ЧИХ-03/410  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
тов тогтоох тухай

Монгол Улсын үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-т заасан бүрэн эрхийнхээ дагуу "Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийг санаачлан боловсруулсныг хянан үзэж Монгол Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэхээр хүргүүлж байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, Засгийн газраас ирүүлсэн дүгнэлтийг хавсаргав.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Н.ЭНХБОЛД



000005



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2022 он 01 дугаар  
сарын 11 -ны өдөр

Дугаар ХЭГ/65

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Н.ЭНХБОЛД  
ТАНАА

Хуралдааны тэмдэглэл  
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлсэн Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн хуралдааны 1 дүгээр тэмдэглэлд:

"ХI.ХЭЛЭЛЦСЭН нь:

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын санаачлан боловсруулсан Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын санаачлан боловсруулсан Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараахь саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:


1. Улсын Их Хурлаас 2018 онд Дэлхийн худалдааны байгууллагын "Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр"-ийг соёрхон баталсантай холбогдуулан Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас санаачлан боловсруулж, 2021 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Иймд хуулийн төслийн 2 дугаар зүйлийг Засгийн газраас санаачлан боловсруулсан дээрх хуулийн төсөлтэй уялдуулж "Иргэний агаарын хөлөг, хөдөлгүүр болон газар дээрх дадлагажуур, тэдгээрийн эд анги, бүрэлдэхүүн хэсэг, дэд угсралтын хэсэг, сэлбэг, тоног төхөөрөмж, холбогдох хэрэгсэл" гэж өөрчлөх;

2. Татварын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.3-т заасан татвар зайлшгүй байх, шударга байх зарчмын хүрээнд Засгийн газраас цаашид тусгайлан салбар, үйл ажиллагааг онцлогоос хамааран татвараас хөнгөлж, чөлөөлөхгүй байх бодлого, зарчим баримталж байгаа бөгөөд Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль батлагдан хэрэгжиж эхлээд байгаа энэ үед төсвийн орлого буурахаар байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчимд нийцэхгүй байгааг анхаарах.


Түүнчлэн, манай улсын хувьд эдийн засаг, төсвийн орлогод эзлэх татварын хөнгөлөлт, чөлөөлөлт бусад орнуудтай харьцуулахад ихээхэн өндөр бөгөөд үе шаттай бууруулах шаардлагатай болохыг Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагуудаас сүүлийн жилүүдэд тогтмол зөвлөж ирснийг анхаарах шаардлагатай байна;

3. Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл болон танилцуулгыг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төслийн бүтэц, зүйл хоорондын уялдаа, бусад хууль тогтоомжтой уялдсан байдал, эх бичвэр, хэл зүй, найруулгад тавигдах нийтлэг шаардлага зэргийг анхаарч боловсруулах." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

БАТЛАВ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  Н.ЭНХБОЛД

ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН  
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль нь 2008 онд батлагдаж, гаалийн тариф, барааны үнэ, ангилал, гарал үүслийг тодорхойлох, гаалийн болон бусад татвар ногдуулах, хураах, төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулж байгаа бөгөөд цаг үеийн шаардлагаар 8 удаа холбогдох өөрчлөлтийг оруулсан байна.

Монгол Улсын Их Хурлаас 2015 онд баталсан Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгийн 2.1-д "Батлан хамгаалах үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд Монгол Улсын тусгаар тогтол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдлыг хангах, хамгаалах зорилго бүхий улс тэр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх нэгдмэл удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтын цогц мөн" гэж, 4.5-д "Монгол Улсын батлан хамгаалах нөөцийн менежмент, түүнд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, батлан хамгаалах зориулалт бүхий материаллаг нөөцийг бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх тогтолцоог төгөлдөржүүлнэ" гэж, 6.2-т "Монгол Улсын батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны харилцааг зохицуулах хууль, эрх зүйн хэм хэмжээний цогц байдлыг хангана" гэж, Батлан хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т "Батлан хамгаалах үйл ажиллагааны зорилго нь Монгол Улсын тусгаар тогтол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хамгаалах, иргэний аюулгүй байдлыг хангахад оршино" гэж, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Эх орныхоо тусгаар тогтолыг батлан хамгаалах нь төрийн үүрэг мөн. Тэр нь улсыг батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, бэхжүүлнэ" гэж, гэж, 20 дугаар зүйлийн 20.1-д "Батлан хамгаалах үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ" гэж, Зэвсэгт хүчний тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Зэвсэгт хүчнийг улсын төсвөөс санхүүжүүлнэ" гэж тус тус заасан.

Түүнчлэн Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгийн Зэвсэгт хүчний үүрэг, түүнийг хөгжүүлэх чиглэлийн 8.2.5-д "байлдааны зэвсэг, цэргийн техник, материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх" гэж, Батлан хамгаалах тухай хуулийн 13.1.10-д "зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байх" гэсэн, мөн зүйлийн 13.1.11-д "цэргийн зориулалттай зэвсэглэл, техник, галт хэрэглэлийг үйлдвэрлэх, экспортлох, импортлох, хангах, хадгалах журмыг тогтоох" гэж, Зэвсэгт хүчний тухай хуулийн 6.2.5-д "зэвсэглэл, цэргийн техник, материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, хадгалах, сольж шинэчлэх" гэж тус тус заасан нь энэхүү хуулийн төслийг боловсруулах эрх зүйн үндэслэл юм.

Практик үндэслэл, шаардлагын хувьд өнөөдрийн байдлаар батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь цэргийн гадаад хамтын ажиллагааны хүрээнд дэлхийн 36 улстай цэргийн болон цэрэг-техникийн дипломат харилцаатай ажиллаж байна.

Зэвсэгт хүчинд ашиглагдаж байгаа цэргийн зэвсэглэл, техник, тоног төхөөрөмжийн 90 гаруй хувийг ОХУ (хуучнаар ЗСБНХУ) -ын бүтээгдэхүүн эзэлдэг бөгөөд эдгээрийн ихэнх хувийг буцалтгүй тусламжаар манай улсад нийлүүлсэн байдаг.

Сүүлийн жилүүдэд ОХУ, БНХАУ, БНТУ, Украян Улс, Белерусь Улстай цэрэг-техникийн салбарт, АНУ, ХБНГУ, БНСУ, Израйль Улс, ИБУИНВУ-тай цэргийн салбарт хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулан, Зэвсэгт хүчний зэвсэглэл, техник, хэрэгслийг сольж шинэчлэх, энхийг дэмжих ажиллагааны оролцох чадавхыг бэхжүүлэхэд онцгой анхааран хамтран ажиллаж байна.

Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Батлан хамгаалах үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ", Зэвсэгт хүчний тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Зэвсэгт хүчний улсын төсвөөс санхүүжүүлнэ" гэж тус тус заасан хэдий ч улс орны төсөв, санхүүгийн хүндрэлтэй байдалтай холбогдуулан цэргийн зэвсэглэл, сум, галт хэрэглэл, сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрэн бурдүүлж, шинэчлэх боломж дутмаг байсаар ирсэн бөгөөд гагцхүү салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд буцалтгүй тусламжаар тодорхой хэмжээний дэмжлэг, туслалцааг авч ирсэн.

Өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа "Гаалийн тариф, гаалийн татварын тухай" хуулийн 38.1.2.-д "хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжийн бараа" гэж, "Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай" хуулийн 13.1.3.-д "гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллагаас буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламж, хөнгөлөлттэй зээлээр авсан бараа" гэж, мөн хуулийн 13.1.5.-д "зэвсэгт хүчин, цагдаа, улсын аюулгүй байдлыг хангах, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын болон Авилгатай тэмцэх газрын хэрэгцээнд зориулан импортоор оруулж байгаа зэвсэг, тусгай техник, хэрэгсэл"-ийг холбогдох татвар, хураамжаас тус тус чөлөөлнө гэсэн эрх зүйн зохицуулалт үйлчилж байгаа ч худалдааны гэрээний хүрээнд Зэвсэгт хүчний хэрэгцээнд зориулан авч буй сум, галт хэрэглэл, нисдэг тэрэг, түүний дагалдах сэлбэг хэрэгсэл, танкийн батарей болон энгийн зориулалттай автомашин гэх мэт бараа, материалд ногдох гааль, нэмэгдсэн өртгийн албан татвар, хураамжийг төлөхтэй холбогдсон асуудал нь батлан хамгаалах салбарын тухайн жилийн төсөвт тусгагдаагүйгээс түүнийг төлөхтэй холбогдсон асуудал ихээхэн хүндрэл учруулж байгаа болно.

Иймд Зэвсэгт хүчний зэвсэглэл, техник, бусад хэрэгслийг үе шаттай шинэчлэх, нөөц бүрдүүлэх уян хатан тогтолцоог бий болгох, худалдан авахад зориулсан төсвийн хөрөнгийг үр дүнтэй захиран зарцуулах арга хэмжээний хүрээнд импортоор оруулж байгаа цэргийн зэвсэглэл техник, сум, галт хэрэглэл, сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж, бусад материал хэрэгслийг гаалийн тариф, гаалийн татвар болон холбогдох бусад татвараас чөлөөлөхтэй холбогдсон эрх зүйн зохицуулалтыг хуулиар бий болгох хэрэгцээ, шаардлага үүссэн болно.

Дээрх хууль, эрх зүйн болон практик хэрэгцээ, шаардлагын үүднээс Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж хууль санаачлагчийн зүгээс хуулийн төслийг боловсруулна.

## **Хоёр. Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээний талаар**

Дээр дурдсан үндэслэл, шаардлагын дагуу Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь 2 зүйлтэй ба тус хуулийн 38 дугаар зүйлд заасан гаалийн татвараас чөлөөлөгдөх бараатай холбогдох харилцааг боловсронгуй болгох зохицуулалтыг тусгах хуулийн төслийг боловсруулна.

### **Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх саналын талаар**

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон түүнд нийцүүлэн шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар Монгол Улсын Үндсэн хуулийн арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эх орныхоо тусгаар тогтолцоог батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн” гэж заасан суурь зохицуулалт хангаждаж, батлан хамгаалах салбарт гадны тусламж, дэмжлэгээр оруулж ирж байгаа буцалтгүй туламжийн бараа болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан цэргийн зэвсэглэл, бусад бараа материал гаалийн болон бусад татвараас чөлөөлөгдөх эрх зийн үндэс бурдэж, Зэвсэгт хүчний хуулиар хүлээсэн чиг үүрэг болон Зэвсэгт хүчнийг чадавхжуулах боломж улам дээшлэх юм.

### **Дөрөв. Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар**

Энэхүү хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Батлан хамгаалах тухай, Зэвсэгт хүчний тухай хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай болон Онцгой албан татварын тухай хууль, Гаалийн тухай хууль тогтоомжид холбогдох өөрчлөлтийг оруулах хуулийн төслийг боловсруулна.

**ХУУЛЬ САНААЧЛАГЧ**

## ТАНИЛЦУУЛГА

*Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар*

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль нь 2008 онд батлагдаж, гаалийн тариф, барааны үнэ, ангилал, гарал үүслийг тодорхойлох, гаалийн болон бусад татвар ногдуулах, хураах, төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулж байгаа бөгөөд цаг үеийн шаардлагаар 8 удаа холбогдох өөрчлөлтийг оруулсан байна.

“Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгийн Зэвсэгт хүчний үүрэг, түүнийг хөгжүүлэх чиглэлийн 8.2.5-д “байлдааны зэвсэг, цэргийн техник, материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх” гэж, Батлан хамгаалах тухай хуулийн 13.1.10-д “зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого, тесөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байх” гэж, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Батлан хамгаалах үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж, Зэвсэгт хүчний тухай хуулийн 6.2.5-д “зэвсэглэл, цэргийн техник, материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, хадгалах, сольж шинэчлэх” гэж, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Зэвсэгт хүчнийг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж тус тус заасан.

Хуулийн төслийн үзэл баримтлалд заасан төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн холбогдох зорилтууд, хууль тогтоомжид заасан эрх зүйн зохицуулалтын хүрээнд Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар Зэвсэгт хүчний бэлэн байдал, орчин үеийн цэргийн зэвсэглэл, техник, галт хэрэглэл, материал хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, хуулиар хүлээсэн чиг үүргээ гүйцэтгэх чадавхийг нэмэгдүүлэх боломж, шаардлага нь энэхүү хуулийн төслийг боловсруулах эрх зүйн үндэслэл болсон.

Дээр дурьдсан хууль тогтоомжид заасан эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх үндсэн шалгуур нь Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд орчин үеийн цэргийн зэвсэглэл, техник, сум, галт хэрэглэл, материал хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх явдал бөгөөд здгээрийн нөөцийг төлөвлөсөн хэмжээнд бүрдүүлэх, шинэчлэх шаардлага жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа юм.

Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Батлан хамгаалах үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ”, Зэвсэгт хүчний тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Зэвсэгт хүчнийг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж тус тус заасан хэдий ч улс орны төсөв, санхүүгийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан цэргийн зэвсэглэл, техник, сум, галт хэрэглэл, сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрэн бүрдүүлж, шинэчлэх боломж дутмаг байсаар ирсэн бөгөөд гагцхүү салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд буцалтгүй тусламжаар дээрх асуудлыг тодорхой хэмжээгээр шийдэж ирсэн болно.

Тодруулбал, 2016-2020 оны хооронд ОХУ-аас 170 орчим тэрбум төгрөгийн үнэ бүхий сургууль-байлдааны сөнөөгч онгоц, нисэх буудлын газрын үйлчилгээний

техник, тоног төхөөрөмж, БНХАУ-аас 3 тэрбум төгрөгийн үнэ бүхий хүн тээврийн автобус, инженерийн техник, "Ковид-19" цар тахлын үед хэрэглэх хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж, АНУ-аас 34,7 тэрбум төгрөгийн үнэ бүхий инженерийн техникууд, хөнгөн хуягласан автомашин, компьютер, сургалтын материал, хээрийн II шатны эмнэлэгийн хэрэгсэл, ХБНГУ-аас 5,5 тэрбум төгрөгийн үнэ бүхий шатахуун тээвэрлэгч, техникийн засвар-үйлчилгээний байр, зөврийн амьсгалын аппарат, Ковид-19 цар тахлын халдварт өвчинтэй тэмцэхэд шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийг тус тус хүлээн авсан байна.

Цаашид БНХАУ, ОХУ, БНЧУ-аас техник хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэхэд Гаалийн болон нэмэгдсэн өргтийн албан татвар, Онцгой албан татварыг төлөх санхүүгийн эх үүсвэр байхгүй бөгөөд ойролцоогоор 5,1 тэрбум төгрөгний гаалийн болон бусад татвар төлөх хүндрэлтэй нөхцөл байдал бий болоод байгаа юм.

Иймд Зэвсэгт хүчний зэвсэглэл, техник, бусад хэрэгслийг үе шаттай шинэчлэх, нөөц бүрдүүлэх уян хатан тогтолцоог бий болгох, худалдан авахад зориулсан төсвийн хөрөнгийг үр дүнтэй захиран зарцуулах арга хэмжээний хүрээнд импортоор оруулж байгаа цэргийн зэвсэглэл, техник, сум, галт хэрэглэл, сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж, бусад материал хэрэгслийг гаалийн тариф, гаалийн татвар болон холбогдох бусад татвараас чөлөөлөхтэй холбогдсон эрх зүйн зохицуулалтыг хуулиар бий болгох хэрэгцээ, шаардлага үүссэн болно.

Дээрх хууль, эрх зүйн болон практик хэрэгцээ, шаардлагын үүднээс Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж хууль санаачлагчийн зүгээс хуулийн төслийг боловсрууллаа.

## ХУУЛЬ САНААЧЛАГЧ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

**1/ 38 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 20 дахь заалт:**

“38.1.20. батлан хамгаалах зориулалт бүхий импортоор оруулах цэргийн зэвсэглэл, галт хэрэглэл, энгийн болон тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, түүний сэлбэг, бусад төрлийн бараа, материал гэж;”

**2 дугаар зүйл.** Гаалийн тариф, гаалийн албан татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.9 дэх заалтыг дор дурьдсанаар өөрчлөн найруулсугай.

“38.1.9. улсын нисэхийн агаарын хелөг болон иргэний агаарын зорчигч тэзврийн хелөг онгоц, тэдгээрийн сэлбэг” гэж;

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нэмэгдсэн өргийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн нийруулсугай:

"13.1.5. төрийн цэргийн байгууллага болон тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр биелүүлэх, төрийн тусгай хамгаалалт, Авлигатай тэмцэх газрын албан хэрэгцээнд зориулан импортоор оруулж байгаа зэвсэг, техник, тусгай зориулалтын тоног төхөөрөмж, түүний сэлбэг, материал хэрэгсэл, галт хэрэглэл;

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Онцгой албан татварын тухай хуульд дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалт:

"7.1.8.батлан хамгаалах зориулалтаар болон Зэвсэгт хүчний хэрэгцээнд импортлосон техник хэрэгсэл."

Гарын үсэг

# **ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот  
2021 он

## **ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид “аргачлал” гэх-/ын дагуу тооцлоо.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог аргачлалын дагуу тооцохын зорилго нь иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардлын ачааллыг тооцож, цаашид гарах ачааллыг багасгах санал боловсруулахад энэхүү судалгааны зорилго оршино.

Уг аргачлалын 1.5 дахь хэсэгт заасан журмын дагуу Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухайд төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдэд оногдох зардал байгаа эсэхэд тооцож үзэв.

### **1. Иргэн, хуулийн этгээдэд үүсэх зардал**

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгийн эдийн засгийн чиглэлд “Батлан хамгаалах арга хэмжээний зардлыг Монгол Улсын төсөөвөс болон хуульд заасан бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ. ... ” гэж заасан ба Зэвсэглэл, техник, тоног төхөөрөмж, галт хэрэглэлийг гаалийн тариф, гаалийн татвараас чөлөөлөхтэй холбогдмон эрх зүйн зохицуулалтыг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар бий болгосноор иргэн, хуулийн этгээдэд нэмэлт зардал үүсэхгүй болно.

### **2. Хуулийн төсөлтэй холбогдуулан төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардал**

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцохдоо хуулийн төсөлд тусгагдсан зардал гарах агуулга бүхий заалтыг тодорхойлж, улмаар зардал гарах талаар судалж үзэв.

Манай улсын хувьд батлан хамгаалах, Зэвсэгт хүчиний зэвсэглэл, техникийн 90 гаруй хувийг ОХУ-ын бүтээгдэхүүн эзэлдэг бөгөөд эдгээрийн ихэнх хувийг сүүлийн 20 гаран жилийн хугацаанд буцалтгүй тусламжаар нийлүүлсэн байдаг.

Батлан хамгаалах яам нь дэлхийн 36 улстай цэргийн дипломат харилцааг тогтоож, салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж байна. Үүнээс ОХУ, БНХАУ, БНТУ, Украян Улс, Белерусь Улстай цэрэг-техникийн салбарт, АНУ, ХБНГУ, БНСУ, Израйль Улс, ИБУИНВУ-тай цэргийн салбарт хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулан Зэвсэгт хүчиний зэвсэглэл, техник, хэрэгслийг сольж шинэчлэх, энхийг дэмжих ажиллагааны оролцох чадавхыг бэхжүүлэх, цэргийн алба хаагчдыг сургаж, бэлтгэх, хамтарсан сургалт, дадлагыг зохион байгуулах зэрэг чиглэлээр хамтран ажиллаж байна.

Тухайлбал; 2016-2020 оны хооронд ОХУ-аас 166,0 тэрбум тэгрэгийн үнэ бүхий Т-72 танкийн хавчуурга гол төмөр, нисэх буудлын газрын үйлчилгээний техник, тоног

төхөөрөмж, сургууль-байлдааны сөнөөгч онгоц, БНХАУ-аас 3, 4 тэрбум төгрөгийн үнэ бүхий хүн тээврийн автобус, инженерийн техник, "Ковид-19" цар тахлын үед хэрэглэх хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж, АНУ-аас 34,7 тэрбум төгрөгийн үнэ бүхий инженерийн техникууд, хөнгөн хуягласан автомашин, компьютер, англи хэлний сурах бичиг, хээрийн II шатны эмнэлэг, ХБНГУ-аас 5,5 тэрбум төгрөгийн үнэ бүхий шатахуун тээвэрлэгч, техникийн засвар-үйлчилгээний байр, зөөврийн амьсгалын аппарат, Ковид-19 цар тахлын халдварт өвчинтэй тэмцэхэд шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийг тус тус хүлээн авсан. Үүний зэрэгцээ Зэвсэгт хүчний зэвсэглэл, техник, сургалт бэлтгэлийн бэлэн байдлыг хангах зорилгоор худалдааны гэрээгээр 2018 онд ОХУ-аас 96,190.60 ам.долларын үнэ бүхий 7,62 мм сум 253,000 ширхэгийг, 2019 онд 13,234,000.00 рублийн үнэ бүхий нисдэг тэрэгний сүүлний сэнс 2 ижийг, 63,000.00 евргийн үнэ бүхий Т-72 танкийн тусгай зориулалтын 6СТ-140N загварын 252 ширхэг тус тус худалдан авсан бөгөөд "Гаалийн тариф, татварын тухай хууль"-д зохицуулалт байхгүйн улмаас 114,341,746.00 төгрөгийн гаалийн татвар ногдож, үүнээс 62 сая орчим төгрөгийн төлөлтийг хийсэн.

Цаашид БНХАУ-аас нийт 70 сая буюу 30.4 тэрбум төгрөгийн буцалтгүй тусламж, ОХУ-аас худалдааны гэрээгээр 1,7 сая ам.долларын үнэ бүхий нисдэг тэрэг, 2,2 сая евргийн үнэ бүхий радиолокацийн станц, БНЧУ-аас 5, 8 тэрбум төгрөгийн үнэ бүхий сум, галт хэрэглэлийг худалдан авахаар гэрээ байгуулсан боловч 5,1 тэрбум төгрөгийн гааль, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх төлбөрийн хүндрэлтэй асуудал жил болгон бидний өмнө тулгарч байна. Энэ нь шууд төсөв хөрөнгөтэй холбоотой. Өөрөөр хэлбэл, Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны хүрээнд гадаадын улс, орнуудаас үзүүлж буй тусламжууд цаг хугацааны хувьд хэзээ хэрэгжих нь тодорхой бус байдаг бөгөөд тухайн хандивлагч улсаас шууд хамааралтай тул батлан хамгаалах төсөвт тусламжийн бараа материалыг хүлээн авахад төлөгдөг гааль, нэмэгдсэн өртгийн болон онцгой албан татварын зардлыг тусгах боломжгүй юм. 2020-2024 онд буцалтгүй тусламж болон худалдааны гэрээгээр доорх зэвсэглэл, техник, бараа материалыг хүлээн авахаар төлөвлөж байгаа ба хуулийн зохицуулалтаас хамаарч ногдох татвар хураамжийг тооцсон болно. Үүнд:

№	Хүлээн авах буцалтгүй тусламж болон худалдааны гэрээ	Гэрээний дүн	Хуулиар ногдох татвар, хураамж	
			НАӨТ-10% /төгрөг/	Гааль-5.5 % /төгрөг/
1	БНХАУ-аас үзүүлэх буцалтгүй тусламж /Арматур, автобус, гал тогооны тоног төхөөрөмж/	70 сая юань	7,000,000.00 юань төлөх	хуулийн 38.1.2
2	ОХУ-аас Ми-8Т загварын 1 нэгж нисдэг тэрэг	1,780,000.0 ам.доллар	Хуулийн 13.1.5	178,000.00 ам.доллар

	худалдан авах			төлөх
3	БНЧУ-аас П-18 радиолокацийн станцыг худалдан авах	2,210,000.0 евро	Хуулийн 13.1.5	221,000.00 евро төлөх
4	БНЧУ-аас Өмнөд Судан Улсад үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн багт шаардлагатай галт хэрэглэлийг худалдан авах	5,800,000,000.0 төгрөг	580,000,000.00 төгрөг төлөх	319,000,000.00 төгрөг төлөх
Татвар төлөх нийт дүн			3,612,610,000.00	1,572,708,990.00
Бүгд				5,185,318,990.00

/Тайлбар: Монгол банкны 2020 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн ханшаар ам.долларыг 2,848.94 төгрөгөөр, еврог 3,378.27 төгрөгөөр, юанийг 433.23 төгрөгөөр тус тус тооцов./

Улс орныг батлан хамгаалах чиглэлээр импортоор оруулж ирж байгаа зэвсэглэл, тусгай техник хэрэгсэл, хоёрдмол зориулалттай бүтээгдэхүүн, галт хэрэглэл, сэлбэг, тоног төхөөрөмж, хэрэгсэлд төлөх гаалийн татвараас чөлөөлснөөр батлан хамгаалах, Зэвсэгт хүчиний үйл ажиллагааны бэлэн байдал, орчин үеийн цэргийн зэвсэглэл, тусгай техник, тоног төхөөрөмж, хэрэгслээр бүрэн хангагдсан, хуулиар хүлээсэн чиг үүргээ гүйцэтгэх чадавхи нэмэгдсэн, төсвийн үр ашигтай, хэмнэлттэй захиран зарцуулалт бий болох боломж бүрдэх юм.

Мөн дээр дурдсан боломжуудаас гадна Батлан хамгаалах, Зэвсэгт хүчиний талаар баримтлах бодлого, зорилго, зорилтоо хэрэгжүүлэхэд томоохон дэмжлэг болохын зэрэгцээ Зэвсэгт хүчиний өмнө тулгамдаж байгаа зэвсэглэл, техникийн шинэчлэл хэрэгжих, сургалт бэлтгэлийн түвшин дээшлэх, давуу талууд үүсэх бөгөөд улсын төсөвт нэмэлт зардал гарах зохицуулалтыг хуулийн төсөлд агуулаагүй тул Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд холбогдох зохицуулалтыг тусгаснаар улсын төсөвт шинээр зардал бий болохгүй болно.

---оОо---

# **ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ АЖЛЫН ТАЙЛАН**

Улаанбаатар хот  
2020 он

## **ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ АЖЛЫН ТАЙЛАН**

### **НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилго нь Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний тайван болон дайны байдлын бэлэн байдлыг хангах, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэхэд тэдний зэвсэглэл, техник хэрэгсэл, хоёрдмөл зориулалттай бүтээгдэхүүн, галт хэрэглэл, сэлбэг, тоног төхөөрөмж, хэрэгслийн нөөцийг төлөвлөсөн хэмжээнд бүрдүүлэх, шинэчлэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй захиран зарцуулахын тулд зэвсэглэл, техник, тоног төхөөрөмж, хэрэгслийг гаалийн татвараас чөлөөлөх хэрэгцээ шаардлагаас урган гарч байна.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хууль нь нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлбэртэй байна.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэхдээ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”<sup>1</sup>-д /цаашид “аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

### **ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал
4. Зардал
5. Харилцан уялдаа зэрэг болно.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх /бүрэн илэрхийлж чадсан эсэх/, хуулийн төсөлд туссан зохицуулалт болон арга хэмжээнүүд нь хуулийн төслийн зорилго, зорилтод хүрэх боломжтой байдлаар томьёологдсон эсэхийг үнэллээ.

Энэхүү үнэлгээг хийхийн тулд хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, хуулийн төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авав.

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг тооцож үзсэн.

<sup>1</sup>Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан

**“Ойлгомжтой байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хамаарах этгээдүүдээс санал авах, хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

**“Зардал”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь төрийн байгууллагад учрах зардлыг бууруулах боломжийг бий болгох ба субъектэд үүсэх зардлыг “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тооцохоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгов.

**“Харилцан уялдаа”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хуульд нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцов.

## **ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ**

**“Зорилгод хүрэх байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилт, холбогдох зохицуулалтууд нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилт, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийнэ.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичиг, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуультай нийцүүлэн боловсруулсан ба дагалдан бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах юм.

### **Эрх зүйн зохицуулалт:**

Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгийн 2.1-д “Батлан хамгаалах үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд Монгол Улсын тусгаар тогтол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдлыг хангах, хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх нэгдмэл удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтын цогц мөн.” гэж, Батлан хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Батлан хамгаалах нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг мөн.”, 5.2-т “Батлан хамгаалах үйл ажиллагааны зорилго нь Монгол Улсын тусгаар тогтол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хамгаалах, иргэний аюулгүй байдлыг хангахад оршино.” гэж тус тус заасан.

Мөн бодлогын үндэс баримт бичгийн 8.2.5-д “байлдааны зэвсэг, цэргийн техник, материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх”-ээр, Батлан хамгаалах тухай хуулийн 13.1.10-д “зэвсэглэл, цэргийн техникиг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого, төсөл, хетөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байх”-аар, 13.1.11-д “цэргийн зориулалттай зэвсэглэл, техник, галт хэрэглэлийг үйлдвэрлэх, экспортлох, импортлох, хангах, хадгалах журмыг тогтоох”-оор, Зэвсэгт хүчиний тухай хуулийн 6.2.5-д “зэвсэглэл, цэргийн техник, материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, хадгалах, сольж шинэчлэх”-ээр тус тус тусгасан.

Энэхүү бодлогын баримт бичиг болон батлан хамгаалахын багц хуулиудад тусгасан зорилтын хүрээнд Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний тайван болон дайны байдлын бэлэн байдлыг хангах, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэхэд тэдний зэвсэглэл, техник хэрэгсэл, хоёрдмол зориулалттай бүтээгдэхүүн, галт хэрэглэл, сэлбэг, тоног төхөөрөмж, хэрэгслийн неецийг төлөвлөсөн хэмжээнд бүрдүүлэх, шинэчлэх шаардлагыг хэрэгжүүлэх, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулахын тулд Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл, хэрэгцээ шаардлага урган гарч байна.

Энэхүү бодлогын үндэс баримт бичгийн 2.1, 8.2.5, Батлан хамгаалах тухай хуулийн 5.1, 5.2, 13.1.10, 13.1.11, Зэвсэгт хүчний тухай хуулийн 6.2.5-д ззасан заалтууд нь тус хуулийн төслийн суурь зохицуулалт болж байна.

### Практик хэрэгжилтийн байдал:

Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний тайван болон дайны байдлын бэлэн байдлыг хангах, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэхэд тэдний зэвсэглэл, техник хэрэгсэл, хоёрдмол зориулалттай бүтээгдэхүүн, галт хэрэглэл, сэлбэг, тоног төхөөрөмж, хэрэгслийн нөөцийг төлөвлөсөн хэмжээнд бурдуулэх, шинэчлэх, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй захиран зарцуулах шаардлагатай байна.

Төсөв санхүүгийн хундрэлтэй байдлаас үүдэж тэр бүр хангалттай хэмжээнд цэргийн зэвсэглэл, тусгай техник хэрэгсэл, хоёрдмол зориулалттай бүтээгдэхүүн, галт хэрэглэл, сэлбэг, тоног төхөөрөмж, хэрэгслийн нөөцийг бүрэн бурдуулж, шинэчилж чадаагүй байна.

Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний зэвсэглэл, техникийн 90 гаруй хувийг ОХУ-ын бүтээгдэхүүн эзэлдэг бөгөөд эдгээрийн ихэнх хувийг буцалтгүй тусламжаар нийлүүлсэн байдаг.

Батлан хамгаалах яам нь дэлхийн 36 улстай цэргийн дипломат харилцааг тогтоож, салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж байна. Үүнээс ОХУ, БНХАУ, БНТУ, Украян Улс, Белерусь Улстай цэрэг-техникийн салбарт, АНУ, ХБНГУ, БНСУ, Израйль Улс, ИБУИНВУ-тай цэргийн салбарт хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулан Зэвсэгт хүчний зэвсэглэл, техник, хэрэгслийг сольж шинэчлэх, энхийг дэмжих ажиллагааны оролцох чадавхыг бэхжүүлэх, цэргийн алба хаагчдыг сургаж, бэлтгэх, хамтарсан сургалт, дадлагыг зохион байгуулах зэрэг чиглэлээр хамтран ажиллаж байна.

Тухайлбал; 2016-2020 оны хооронд ОХУ-аас 166,0 тэрбум төгрөгийн үнэ бүхий Т-72 танкийн хавчуурга гол төмөр, нисэх буудлын газрын үйлчилгээний техник, тоног төхөөрөмж, сургууль-байлдааны сенеөгч онгоц, БНХАУ-аас 3, 4 тэрбум төгрөгийн үнэ бүхий хүн тээврийн автобус, инженерийн техник, "Ковид-19" цар тахлын үед хэрэглэх хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж, АНУ-аас 34,7 тэрбум төгрөгийн үнэ бүхий инженерийн техникууд, хөнгөн хуягласан автомашин, компьютер, англи хэлний сурх бичиг, хээрийн II шатны эмнэлэг, ХБНГУ-аас 5,5 тэрбум төгрөгийн үнэ бүхий шатахуун тээвэрлэгч, техникийн засвар-үйлчилгээний байр, зөөврийн амьсгалын аппарат, Ковид-19 цар тахлын халдварт өвчинтэй тэмцэхэд шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийг тус тус хүлээн авсан. Үүний зэрэгцээ Зэвсэгт хүчний зэвсэглэл, техник, сургалт бэлтгэлийн бэлэн байдлыг хангах зорилгоор худалдааны гэрээгээр 2018 онд ОХУ-аас 96,190.60 ам.долларын үнэ бүхий 7,62 мм сум 253,000 ширхэгийг, 2019 онд 13,234,000.00 рублийн үнэ бүхий нисдэг тэрэгний сүүлний сэнс 2 ижийг, 63,000.00 еврогийн үнэ бүхий Т-72 танкийн тусгай зориулалтын 6СТ-140N загварын 252 ширхэг тус тус худалдан авсан бөгөөд "Гаалийн тариф, татварын тухай хууль"-д зохицуулалт байхгүйн улмаас 114,341,746.00 төгрөгийн гаалийн татвар ногдож, үүнээс 62 сая орчим төгрөгийн төлөлтийг хийсэн.

Цаашид БНХАУ-аас нийт 70 сая буюу 30.4 тэрбум төгрөгийн буцалтгүй тусламж, ОХУ-аас худалдааны гэрээгээр 1,7 сая ам.долларын үнэ бүхий нисдэг тэрэг, 2,2 сая еврогийн үнэ бүхий радиолокацийн станц, БНЧУ-аас 5, 8 тэрбум төгрөгийн үнэ бүхий сум, галт хэрэглэлийг худалдан авахаар гэрээ байгуулсан бөгөөд холбогдох хуулийн зохицуулалт байхгүйн улмаас 5,1 тэрбум төгрөгийн гааль, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх асуудал үүсэхээр байна.

Дээр дурдсан хэрэгцээ, шаардлагыг шийдвэрлэх зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.2-т заасны дагуу Гаалийн тариф.

гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Аливаа хуулийн зохицуулалт нь хуулийн тесөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн байх ёстой учраас хамгийн эхэнд хуулийн төслийн зорилгыг хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлага, үндэслэл болон зорилготой харьцуулан дараах байдлаар үнэлэх хэсгээ тогтоолоо.

Хуулийн төслийн хэрэгцээ шаардлага Үндсэн зорилго, дэд зорилго/ хуулийн төслийн үзэл баримтлалаас	Хуулийн төслийн зорилго
Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний тайван болон дайны байдлын бэлэн байдлыг хангах, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэхэд тэдний зэвсэглэл, техник хэрэгсэл, хоёрдмол зориулалттай бүтээгдэхүүн, галт хэрэглэл, сэлбэг, тоног төхөөрөмж, хэрэгслийн нөөцийг төлөвлөсөн хэмжээнд бүрдүүлэх, шинэчлэх, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй захиран зарцуулах асуудлыг шийдвэрлэх боломж илүү бүрдэх юм.	<p>-Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний тайван болон дайны байдлын бэлэн байдлыг хангах, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэхэд тэдний зэвсэглэл, техник хэрэгсэл, хоёрдмол зориулалттай бүтээгдэхүүн, галт хэрэглэл, сэлбэг, тоног төхөөрөмж, хэрэгслийг гаалийн татвараас чөлөөх зохицуулалтыг тусгах.</p> <p>-Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний тайван болон дайны байдлын бэлэн байдлыг хангах, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэхэд тэдний зэвсэглэл, техник хэрэгсэл, хоёрдмол зориулалттай бүтээгдэхүүн, галт хэрэглэл, сэлбэг, тоног төхөөрөмж, хэрэгслийг жагсаалыг Засгийн газар батлах зохицуулалтыг тусгах.</p>

“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн тесөлд шинээр тусгах зохицуулалтыг сонгож авлаа.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн тесөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэг болон Хууль тогтоомжийн тесөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан байдал, хуулийг ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

## ДӨРӨВ.УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулъя.

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	<p><b>1 дүгээр зүйл.</b> Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах 38 дугаар зүйлд дор дурдсан заалтыг нэмсүгэй:</p> <p><b>1/38 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 20 дахь заалт:</b></p> <p>“38.1.20.Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний зэвсэглэл, техник хэрэгсэл, хоёрдмол зориулалттай бүтээгдэхүүн, галт хэрэглэл, сэлбэг, тоног төхөөрөмж, хэрэгсэл”</p> <p><b>2 дугаар зүйл.</b> Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “38.1.19-д” гэсний дараа “38.1.20-д” гэж нэмсүгэй.</p> <p><b>3 дугаар зүйл.</b> Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “38.1.19-д” гэснийг “38.1.19,” гэж вөрчилсүгэй.</p> <p><b>4 дүгээр зүйлд.</b> Энэ хуулийг 2020 оны ... сарын ... өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. гэж нэмсүгэй.</p>	Хуулийн төслийн зохицуулалтад дүн шинжилгээ хийх
			Хуулийн төслийн зохицуулалтад дүн шинжилгээ хийх
			Хуулийн төслийн зохицуулалтад дүн шинжилгээ хийх
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Ойлгомжтой байдлыг судлах
3	Зардал	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу тусад нь тооцно.	Зардлын тооцоо хийх
4	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:  
 Хуулийн төслийг түүний үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон байдалтай харьцуулан үзэж, холбогдох зохицуулалтын эрх зүйн үр дагаврыг тодорхойлоход чиглэсэн.

**Гаалийн тариф, гаалийн татвар тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл.**

**1/38 дугаар зүйлийн 1 дахь хэсгийн 20 дахь заалт:**

**"38.1.20. Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний зэвсэглэл, техник хэрэгсэл, хоёрдмол зориулалттай бүтээгдэхүүн, галт хэрэглэл, сэлбэг, тоног төхөөрөмж, хэрэгслийн талаар тусгаснаар гаалийн татвараас чөлөөлөгдөх эрх зүйн зохицуулалт тодорхой болно гэж үзсэн.**

**Гаалийн тариф, гаалийн татвар тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл.**

**2 дугаар зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "38.1.19-д" гэсний дараа "38.1.20-д" гэж нэмсүгэй.**

Хуулийн 38.2 дахь хэсэгт "38.1.20-д" гэсэн шинэ заалтыг нэмж тусгаснаар Засгийн газар батлах гаалийн татвараас чөлөөлөгдөх Засгийн газрын батлах Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний зэвсэглэл, техник хэрэгсэл, хоёрдмол зориулалттай бүтээгдэхүүн, галт хэрэглэл, сэлбэг, тоног төхөөрөмж, хэрэгслийн жагсаалт тодорхой болох юм.

**Гаалийн тариф, гаалийн татвар тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл.**

**3 дугаар зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "38.1.19-д" гэснийг "38.1.19," гэж өөрчилсүгэй.**

Хуулийн 38.1-д 38.1.20 дахь заалтыг нэмж тусгаснаар 38.1.19 дахь заалтад өөрчлөлт оруулж тусгасан болно.

**Гаалийн тариф, гаалийн татвар тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйл.**

**4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2020 оны ... сарын ... өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. гэж нэмсүгэй.**

**"Ойлгомжтой байдлыг судлах" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Хуулийн төсөл нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томьёологдсон эсэхийг шалгах үүднээс хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгахдаа

Хууль тогтоомжийн тухай хуулийн дараах заалтад заасан шаардлагыг хангасан эсэхэд хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан.
29.1.2. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Тийм.
29.1.3. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгагүй.
29.1.4. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болгох саналыг тусгагүй.
29.1.5. зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.6. хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7. бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан.
29.1.8. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан.
29.1.9. шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл,	Шаардлага хангасан.

хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага байхгүй болно.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Шаардлага хангасан.
<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага</b>	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх;	Шаардлага хангасан.
30.1.2.нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлээгүй.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан.
30.1.4.хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан.
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан.

**“Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах”шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгахыг зорилгоо.

д/д	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Шаардлага хангасан.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Шаардлага хангасан.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон

	төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа.
